

УУЛ УУРХАЙН САЛБАРЫН 2019 ЭХНИЙ 3 САРЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

II. УУЛ УУРХАЙН САЛБАРААС УЛСЫН ТӨСӨВТ ОРУУЛСАН ТАТВАР, ХУРААМЖ

2018 оны жилийн эцсийн байдлаар улсын төсөвт **2,051.5** тэрбум төгрөг татвар, хураамж хэлбэрээр төвлөрүүлсэн байна. Үүнээс:

- Алт **80.0** тэрбум төгрөг,
- Нүүрс **910.6** тэрбум төгрөг,
- Цайр **76.9** тэрбум төгрөг,
- Зэс **871.9** тэрбум төгрөг,
- Төмөр **17.1** тэрбум төгрөг,
- Жонш **16.3** тэрбум төгрөг,
- Бусад **78.8** тэрбум төгрөг,

Улсын төсөвт орсон орлогыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **456.3** тэрбум төгрөг буюу **28.6** хувиар өссөн. Үүнээс:

- Алт **31.0 (63.1%)** тэрбум төгрөг,
- Нүүрс **306.8 (50.8%)** тэрбум төгрөг,
- Цайр **13.6 (21.5%)** тэрбум төгрөг,
- Зэс **71.1 (8.9%)** тэрбум төгрөг,
- Төмөр **4.7 (38.6%)** тэрбум төгрөг,
- Жонш **4.0 (32.1%)** тэрбум төгрөг,
- Бусад **25.0 (46.5%)** тэрбум төгрөг.

2019 оны эхний 3 дугаар сарын байдлаар улсын төсөвт **666.9** тэрбум төгрөг татвар, хураамж хэлбэрээр төвлөрүүлсэн байна. Үүнээс:

- Алт **8.9** тэрбум төгрөг,
- Нүүрс **317.5** тэрбум төгрөг,
- Цайр **18.1** тэрбум төгрөг,
- Зэс **299.8** тэрбум төгрөг,
- Төмөр **4.9** тэрбум төгрөг,
- Жонш **4.1** тэрбум төгрөг,
- Бусад **13.6** тэрбум төгрөг,

Улсын төсөвт оруулсан орлого өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **218.7** тэрбум төгрөг буюу **48.8** хувиар өссөн. Үүнээс:

- Алт **2.4 (37.5%)** тэрбум төгрөг,
- Нүүрс **165.9 (109.4%)** тэрбум төгрөг,
- Зэс **57.3 (23.6%)** тэрбум төгрөг,
- Жонш **0.7 (20.2%)** тэрбум төгрөг,

Харин

- Цайр **3.9 (17.7%)** тэрбум төгрөг,
- Төмөр **1.2 (20.0%)** тэрбум төгрөг,
- Бусад ашигт малтмал **2.5 (15.4%)** тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

УЛСЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ТАТВАР, ХУРААМЖ, АШИГТ МАЛТМАЛААР

тэрбум төгрөг

Үзүүлэлт	2018		2019		Өөрчлөлт			
	III	I-III	III	I-III	(4-2)=?, (4/2)=%	(5-3)=?, (5/3)=%		
1	2	3	4	5	6	7	8	9
Нийт дүн	94.4	448.2	188.9	666.9	94.5	100.0%	218.7	48.8%
Алт	2.6	6.5	3.8	8.9	1.2	45.8%	2.4	37.5%
Нүүрс	29.9	151.6	133.2	317.5	103.3	345.1%	165.9	109.4%
Цайр	5.5	22.0	6.5	18.1	1.0	19.2%	-3.9	-17.7%
Зэс	50.3	242.5	40.1	299.8	-10.3	-20.4%	57.3	23.6%
Төмөр	0.5	6.1	0.5	4.9	0.0	2.9%	-1.2	-20.0%
Жонш	1.3	3.4	0.8	4.1	-0.5	-39.8%	0.7	20.2%
Бусад	4.3	16.1	3.9	13.6	-0.3	-7.6%	-2.5	-15.4%

II. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

II.1. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

2019 оны эхний 3 дугаар сард **12.9** сая тн нүүрс, **353.2** мян.тн зэсийн баяжмал, **1.3** тн алт, **1.2** мян.тн молибдений баяжмал, **27.2** мян.тн хайлуур жоншны хүдэр, **1.3** мян.тн хайлуур жоншны баяжмал, **1.2** сая тн төмрийн хүдэр, **754.7** мян.тн төмрийн хүдрийн баяжмал, **24.0** мян.тн цайрын баяжмал, **1.7** сая тн бар газрын тос үйлдвэрлэсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нүүрс **2.0** сая тн буюу **17.9%**, зэсийн баяжмал **26.3** мян.тн буюу **8.0%**, төмрийн хүдэр **89.3** мян.тн буюу **7.7%**, цайрын баяжмал **0.6** мян.тн буюу **2.6%**-иар ихээр тус тус өссөн байна.

Харин алт **563.2** кг буюу **30.1%**, молибдены баяжмал **83.8** тн буюу **6.4%**, хайлуур жоншны хүдэр **1.2** мян.тн буюу **4.2%**, хайлуур жоншны баяжмал **11.7** мян.тн буюу **90%**, төмрийн хүдрийн баяжмал **35.3** мян.тн буюу **4.5%**, газрын тос **75.0** мян.бар буюу **4.3%**, катодын зэс **285.7** тн буюу **8.0%**-иар тус тус буурсан байна.

№	Бүтээгдэхүүний төрөл	Хэмжих нэгж	2018		2019		Өөрчлөлт			
			III	I-III	III	I-III	(5-3)=?, (5/3)=%	(6-4)=?, (6/4)=%		
	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Уул уурхай, олборлох аж үйлдвэр									
1.1	Нүүрс	мян.тн	4,435.6	10,933.4	4,887.3	12,887.6	451.7	10.2%	1,954.2	17.9%
1.2	Газрын тос	мян.бар	568.7	1,746.1	569.7	1,671.1	1.0	0.2%	-75.0	-4.3%
1.3	Зэсийн баяжмал, м/агуулгаараа	мян.тн	118.7	326.9	112.4	353.2	-6.3	-5.3%	26.3	8.0%
1.4	Молибдений баяжмал, м/ агуулгаараа	тн	456.1	1,306.9	415.4	1,223.1	-40.7	-8.9%	-83.8	-6.4%
1.5	Алт	кг	594.8	1,870.8	451.4	1,307.6	-143.4	-24.1%	-563.2	-30.1%
1.6	Төмөр:									
	- Төмрийн хүдэр	мян.тн	359.3	1,154.7	722.2	1,244.0	362.9	101.0%	89.3	7.7%
	- Төмрийн хүдрийн баяжмал	мян.тн	439.3	790.0	278.0	754.7	-161.3	-36.7%	-35.3	-4.5%
1.7	Хайлуур жонш:									
	- Хайлуур жоншны хүдэр	мян.тн	9.3	28.4	10.7	27.2	1.4	15.1%	-1.2	-4.2%
	- Хайлуур жоншны баяжмал	мян.тн	11.0	13.0	-	1.3	-11.0	-100.0%	-11.7	-90.0%
1.8	Цайрын баяжмал	мян.тн	8.5	23.4	8.0	24.0	-0.5	-5.9%	0.6	2.6%
2	Боловсруулах аж үйлдвэр									
2.1	Катодын зэс, 99%	тн	1,239.3	3,581.8	1,038.7	3,296.1	-200.6	-16.2%	-285.7	-8.0%
2.2	Металл бэлдэц	тн	3,577.5	8,007.3	615.1	7,811.6	-2,962.4	-82.8%	-195.7	-2.4%
2.3	Металл цувимал	тн	3,946.7	7,760.2	-	7,556.9	-3,946.7	-100.0%	-203.3	-2.6%

Эх сурвалж: ҮСХ

II.2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ

тэрбум төгрөг

Салбар	2018		2019		Өөрчлөлт			
	III	I-III	III	I-III	(4-2)=?, (4/2)=%	(5-3)=?, (5/3)=%		
1	2	3	4	5	6	7	8	9
Нийт дүн	1,197.0	3,267.6	1,335.8	3,839.9	138.9	11.6%	572.3	17.5%
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	862.7	2,334.6	1,000.7	2,832.9	138.0	16.0%	498.4	21.3%
Нүүрс олборлолт	307.9	778.8	472.4	1,284.2	164.5	53.4%	505.4	64.9%
Газрын тос олборлолт	84.2	260.5	85.7	238.1	1.5	1.7%	-22.5	-8.6%
Металлын хүдэр олборлолт	456.4	1,269.3	434.8	1,286.5	-21.6	-4.7%	17.2	1.4%
Бусад ашигт малтмал олборлолт	14.1	25.9	7.9	24.2	-6.3	-44.3%	-1.7	-6.6%
Боловсруулах аж үйлдвэр	237.3	627.1	229.6	672.8	-7.6	-3.2%	45.8	7.3%

Эх сурвалж: УСХ

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2019 оны эхний 3 дугаар сард **3.8** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **572.3 (17.5%)** тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл **2.8** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **498.4 (21.3%)** тэрбум төгрөгөөр, үүнээс нүүрс олборлолт **505.4 (64.9%)** тэрбум төгрөгөөр, металлын хүдэр олборлолт **17.2 (1.4%)** тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн. Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд Уул уурхай, олборлох салбар **73.8%**-ийг эзэлж байна.

II.3. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН

тэрбум төгрөг

Салбар	2018		2019		Гад-дад	Өөрчлөлт			
	III	I-III	III	I-III		(4-2)=?, (4/2)=%	(5-3)=?, (5/3)=%		
1	2	3	4	5	6	7	8	9	10
Нийт дүн	1,467.8	3,822.7	1,794.6	4,613.6	3,416.5	326.8	22.3%	790.9	20.7%
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	1,076.3	2,711.1	1,320.8	3,296.4	2,979.0	244.5	22.7%	585.4	21.6%
Нүүрс олборлолт	402.6	1,020.3	563.1	1,321.4	1,158.4	160.5	39.9%	301.1	29.5%
Газрын тос олборлолт	92.0	243.3	91.6	231.6	231.6	-0.4	-0.4%	-11.7	-4.8%
Металлын хүдэр олборлолт	566.4	1,415.4	649.8	1,702.4	1,564.0	83.5	14.7%	287.0	20.3%
Бусад ашигт малтмал олборлолт	15.3	32.0	16.2	41.0	25.0	0.9	6.0%	0.9	27.8%
Боловсруулах аж үйлдвэр	293.7	803.4	367.5	981.7	437.5	73.8	25.1%	178.3	22.2%

Эх сурвалж: УСХ

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2019 оны эхний 3 дугаар сард **4.6** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **790.9 (20.7%)** тэрбум төгрөгөөр өслөө. Үүнээс уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн **3.3** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **585.4 (21.6%)** тэрбум төгрөгөөр, үүнээс нүүрс олборлолт **301.1 (29.5%)** тэрбум төгрөгөөр, металлын хүдэр олборлолт **287.0 (20.3%)** тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан нийт бүтээгдэхүүнээс **3.4 (74.1%)** их наяд төгрөг, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүнээс **3.0 (64.6%)** их наяд төгрөгийн бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд тус тус борлуулсан байна.

III. ГАДААД ХУДАЛДАА

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2019 оны эхний 3 сарын гүйцэтгэлээр **3,057.4** сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийнхээс **17.0** хувиар буюу **444.5** сая ам.доллараар өссөн байна. Экспорт импортоос давамгайлж экспорт, импортын зөрүү **485.9** сая ам.доллараар эерэг гарсан байна.

III.1. ЭКСПОРТ

Экспорт **1,771.7** сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс **289.3** сая ам.доллараар буюу **19.5** хувиар өссөн байна. Экспортын бүтцээр авч үзвэл, нийт экспортын **83.5** хувь эрдэс бүтээгдэхүүнд, үүнээс **11.1** хувь нь алтны экспорт эзэлж байна.

Эрдэс бүтээгдэхүүний экспорт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018 I-III		2019 I-III		Өөрчлөлт			
			Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Хувь	Үнийн дүн	Хувь
1	Чулуун нүүрс	сая тн/сая \$	6.6	509.4	7.7	641.7	1.1	16.9%	132.3	26.0%
2	Зэсийн хүдэр, баяжмал	мян.тн/сая \$	337.7	462.5	361.4	503.7	23.7	7.0%	41.2	8.9%
3	Боловсруулаагүй нефть	сая бар/сая \$	1.6	101.0	1.6	87.8	-0.01	-0.6%	-13.3	-13.1%
4	Төмрийн хүдэр, баяжмал	сая тн/сая \$	1.4	63.9	2.1	106.5	0.6	43.8%	42.6	66.6%
5	Хайлуур жонш	мян.тн/сая \$	78.3	25.0	110.6	40.6	32.3	41.3%	15.5	62.0%
6	Цайрын хүдэр, баяжмал	мян.тн/сая \$	32.9	60.2	44.0	62.6	11.1	33.7%	2.5	4.1%
7	Молибдены хүдэр, баяжмал	мян.тн/сая \$	1.4	10.1	1.4	11.9	-0.01	-0.8%	1.8	17.7%
8	Хар тугалганы хүдэр, баяжмал	мян.тн/сая \$	4.0	10.6	5.3	12.3	1.3	32.3%	1.6	15.5%
9	Цагаан тугалганы хүдэр, баяжмал	тн/сая \$	25.1	0.3	39.1	0.6	14.0	56.0%	0.3	84.2%
10	Гянтболдын хүдэр, баяжмал	тн/сая \$	50.9	0.7	50.0	0.6	-0.9	-1.7%	-0.1	-21.2%
11	Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт	кг/сая \$	2.9	124.3	4.7	195.9	1.7	58.1%	71.6	57.6%

Эх сурвалж: ГЕГ

Чулуун нүүрсний экспорт 2019 оны эхний 3 сард **641.7** сая ам.долларын **7.7** сая тн өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал үнийн дүнгээр **132.3** сая ам.доллараар, тоо хэмжээний хувьд **1,120.5** мян.тн-оор тус тус их байна. **2018** оны мөн үед 1 тн нүүрсний хилийн дундаж үнэ **77.0** ам.доллар байсан бол энэ онд **83.0** ам.доллар болж өсчээ. Чулуун нүүрсний **97.7%** БНХАУ руу гаргасан байна.

Зэсийн баяжмалын экспорт 2019 оны эхний 3 сард **361.4** мян.тн экспортлосон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс **23.7** мян.тн-оор их байгаа ба хилийн дундаж үнэ **1,369.7** ам.доллараас **1,393.9** ам.доллар болж **24.2** ам.доллараар өссөн байна. 2018 оны эхний 3 сард зэсийн баяжмалын экспорт үнийн дүнгээр **462.5** сая ам.доллар байсан бол тайлант сард **503.7** сая ам.доллар болжээ.

Боловсруулаагүй нефтийн экспорт 2019 оны эхний 3 сард **1,620.6** мян.бар буюу **87.8** сая ам.долларт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс **10.5** мян.бар-аар, үнийн дүнгээр **13.2** сая ам.доллараар тус тус бага байна. 1 баррель нефтийн хилийн дундаж үнэ **61.9** ам.доллар байсан бол тайланд хугацаанд **54.2** ам.доллар болж буурчээ.

Төмрийн хүдрийн экспорт 2019 оны эхний 3 сард **2,071.8** мян.тн буюу **106.5** сая ам.долларт хүрсэн байна. **2018** оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулахад уг бүтээгдэхүүний экспорт **630.9** мян.тн-оор, үнийн дүн нь **42.6** сая ам.доллараар тус тус өсчээ. 1 тн төмрийн хүдрийн экспортын дундаж үнэ **51.4** ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс **7.0** ам.доллараар өссөн байна.

Цайрын баяжмал экспорт 2019 оны эхний 3 сард **43.9** мян.тн цайрын баяжмалын 1 тн-ыг дундажаар **1,424.6** ам.доллараар экспортлосон байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хилийн дундаж үнэ **405.1** ам.доллараар буурсан байна. Цайрын баяжмалын экспорт үнийн дүнгээр **62.6** сая ам.доллар болж, өнгөрсөн оныхоос **2.5** сая ам.доллараар нэмэгджээ.

Хайлуур жоншны экспорт 2019 оны эхний 3 сард **40.6** сая ам.долларын **110.6** мян.тн 2018 оны мөн үеийн гүйцэтгэлээс **32.3** мян.тн-оор, үнийн дүнгээр **15.5** сая ам.доллараар тус тус өссөн байна. Хайлуур жоншны экспортын дундаж үнэ **366.6** ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс **46.9** ам.доллараар өссөн байна. Хайлуур жоншийг БНХАУ, ОХУ, БНСУ руу экспортлосон ба **32.3** хувь ОХУ-д, **67.1** хувь БНХАУ-д тус тус ногдож байна.

Молибдены баяжмалын экспорт 2019 оны эхний 3 сард үнийн дүнгээр **11.9** сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс **1.8** сая ам.доллараар өссөн байна. Тус бүтээгдэхүүний нэг тонны экспортын хилийн дундаж үнэ **7,195.9** ам.доллараас **8,533.0** ам.долларт хүрч, **1,337.1** ам.доллараар өсчээ. 2019 оны эхний 3 сард **1,395.8** тн-ыг экспортлосон нь өнгөрсөн оны мөн үеэс **10.9** тн-оор бага байна. Молибдены баяжмалын **83.6** хувийг БНХАУ руу гаргасан байна.

Алтны экспорт 2019 оны эхний 3 сард **4,665.2** кг өнгөрсөн оны мөн үеийнхээс 1,715.3 кг-аар их байна. Алтны экспортын дундаж үнэ 2018 оны мөн үед **4,2143.2** ам.доллар байсан бол энэ онд **41,998.0** ам.доллар болж **145.2** ам.доллараар багассан байна. Алтны экспорт үнийн дүнгээр **195.9** сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс **71.6** сая ам.доллараар өсчээ.

III.2. ИМПОРТ

Импорт **1,285.7** сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийнхээс **155.3** сая ам.доллараар буюу **13.7** хувиар өссөн байна.

Эрдэс бүтээгдэхүүний импорт **315.4** сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс **36.6** сая ам.доллараар буюу **13.1** хувиар өслөө. Эрдэс бүтээгдэхүүний импортын **84.6** хувийг нефтийн бүтээгдэхүүн эзлэж байна. 2019 оны эхний 3 сард **267.0** сая ам.долларын **438.9** мян.тн нефтийн бүтээгдэхүүн импортлосон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс **35.9** мян.тн-оор, үнийн дүнгээр **94.4** сая ам.доллараар тус тус өсчээ. Нефтийн бүтээгдэхүүний импортын **92.3** хувийг автобензин, дизель түлшний импорт, үүний **35.0** хувийг автобензин, **65.0** хувийг дизель түлшний импорт эзлэж байна.

2019 оны эхний 3 сард **141.8** мян.тн автобензин импортлосон нь 2018 оны мөн үеийн дүнгээс **55.4** мян.тн-оор их байна. 2018 оны мөн үед 1 тн автобензины импортын дундаж үнэ **679.3** ам.доллар байсан бол 2019 онд **545.6** ам.доллар болж **19.7** хувиар буурсан байна.

Дизель түлшний импорт **263.4** мян.тн болж 2018 оны мөн үеийн гүйцэтгэлээс **56.9** мян.тн-оор өссөн байна. 2018 оны эхний 3 сард 1 тн дизель түлшний импортын дундаж үнэ **647.6** ам.доллар байсан бол энэ онд **618.7** ам.долларт хүрч **28.9** ам.доллар буюу **4.5** хувиар буурсан байна. Дизелийн түлшний импорт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **29.2** сая ам.доллараар нэмэгджээ.